



**“МОНГОЛЫН ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧДЫН ХОЛБОО” ТББ-ЫН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 01/23

Улаанбаатар хот

“Монголын Даатгалын Зуучлагчдын холбоо” ТББ – ийн бүх гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТУШААХ НЬ:**


1. “Монголын Даатгалын Зуучлагчдын холбоо” ТББ-ын үндсэн болон дэмжигч гишүүн даатгалын зуучлалын компаниуд мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахдаа Хавсралт 1-т заасан мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийг мөрдлөг болгон ажилсугай.
2. Даатгалын зуучлагчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргэх, үндсэн болон дэмжигч гишүүн даатгалын зуучлалын компаниуд танилцуулах ажлыг Ерөнхий менежер Г.Оргилцолмонд даалгасугай.

*Хавсралтаар дүрмийг хавсаргав.*

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ОТГОНБАЯР



## ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

### I. Дүрмийн зорилго, үйлчлэх хүрээ

- 1.1. Энэхүү дүрмийн зорилго нь даатгалын зуучлалын компаниуд мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад баримтлах нийтлэг, босго стандартыг тогтоох, тэдгээрийг мөрдүүлэх, хэвшүүлэхэд чиглэнэ.
- 1.2. Монголын Даатгалын Зуучлагчдын Холбооны гишүүн Даатгалын зуучлагчид, тэдгээрийн нэрийн өмнөөс ажиллаж буй ажилчид даатгалын зуучлал, түүнтэй холбоотой энэхүү дүрэмд заасан мэргэжлийн үйл ажиллагааг явуулахад энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.
- 1.3. Энэхүү дүрэм нь Даатгалын зуучлагчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах (minimum) стандарт бөгөөд энэхүү дүрмээс тогтоосон стандартаас илүү мэргэжлийн хариуцлага бүхий дүрмийг Даатгалын зуучлагч байгууллагадаа батлан мөрдүүлж болно.

### II. Нэр томъёоны тайлбар

- 2.1. Энэхүү дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно;
  - 2.1.1. “Даатгалын зуучлагч” эсвэл “даатгалын брокер” гэж тусгай зөвшөөрлийн үндсэн дээр даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийг;
  - 2.1.2. “Даатгалын зуучлагчийг төлөөлж ажиллах ажилтан” гэж даатгалын зуучлагчийн явуулж буй мэргэжлийн үйл ажиллагаанд түүнийг төлөөлж ажиллаж буй ажилчдыг;
  - 2.1.3. “Үйлчлүүлэгч” гэж даатгалын зуучлагчаас гэрээний үндсэн дээр мэргэжлийн үйлчилгээ авч буй хувь хүн, хуулийн этгээдийг;
  - 2.1.4. “Харилцагч” гэж даатгалын зуучлагч мэргэжлийн үйл ажиллагаа явуулах явцад харилцаж буй боломжит үйлчлүүлэгч болон үйлчлүүлэгчээс бусад гуравдагч этгээдийг;
  - 2.1.5. “Боломжит үйлчлүүлэгч” гэж даатгалын зуучлагчаас мэргэжлийн үйлчилгээ авах талаар гэрээ байгуулаагүй боловч үйлчилгээ авахаар хүсэл зоригоо илэрхийлж, өөрийн талаар мэдээллээ даатгалын зуучлагчид ил болгосон этгээдийг;
  - 2.1.6. “Мэргэжлийн үйл ажиллагаа” гэж даатгалын зуучлагчаас өөрийн үйлчлүүлэгчид үзүүлж буй даатгагч/даатгуулагчтай даатгалын гэрээ байгуулахад холбож өгч буй даатгалын зуучлалын үйл ажиллагаа, даатгалын нөхөн төлбөр нэхэмжлэхтэй холбоотой болон

үйлчлүүлэгчийн даатгалын холбогдолтой ашиг сонирхлын төлөө явуулах бусад үйл ажиллагааг;

- 2.1.7. “Даатгалын зуучлалын үйл ажиллагаа” гэж үйлчлүүлэгчийг даатгагч эсвэл даатгуулагчтай холбож өгөх, даатгалын гэрээ байгуулахад үйлчлүүлэгчийг төлөөлөх, түүнд зөвлөгөө өгөх үйл ажиллагааг тус тус ойлгоно.

### **III. Үйл ажиллагаанд баримтлах зарчмууд**

- 3.1. Даатгалын зуучлагч нь даатгалын зуучлал, түүнтэй холбоотой энэхүү дүрэмд заасан үйл ажиллагааг явуулахдаа доорх зарчмуудыг дагаж мөрдөнө.
  - 3.1.1. Үйл ажиллагаагаа хууль тогтоомжид нийцүүлэх;
  - 3.1.2. Үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд үнэнч байх;
  - 3.1.3. Сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;
  - 3.1.4. Мэргэжлийн шаардлага хангасан байх;
  - 3.1.5. Үйлчилгээний нууцлалыг хангах;
  - 3.1.6. Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх;
  - 3.1.7. Ил тод, нээлттэй байх, мэдээллээр хангах;

### **IV. Хууль дээдлэх**

- 4.1. Даатгалын зуучлагч нь мэргэжлийн үйл ажиллагаагаа хууль тогтоомжид нийцүүлэх хүрээнд дараах шаардлагыг биелүүлнэ.
  - 4.1.1. Салбарын хууль тогтоомжуудыг тухай бүрт нь судлах, төлөөлж ажиллах ажилчиддаа сургалт орох, шаардлагатай сургалтуудад хамруулж байх, шаардлагатай тохиолдолд хууль зүйн зөвлөх үйлчилгээ авах зэргээр хууль тогтоомж зөрчигдөх эрсдлээс сэргийлэх арга хэмжээ авна.
  - 4.1.2. Даатгалын зуучлагч нь Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, журам, зааврууд болон тэдгээрийн хүрээнд гарсан шийдвэр, албан шаардлагуудыг биелүүлж ажиллана.
  - 4.1.3. Даатгалын зуучлагч нь Санхүүгийн зохицуулах хороо болон бусад төрийн эрх бүхий байгууллагатай байнгын холбоотой байж, хамтарч ажиллана.
- 4.2. Санхүүгийн зохицуулах хороо болон даатгагч, харилцагчийн шийдвэр, үйл ажиллагаа хууль зөрчсөн гэж үзсэн бол энэ тухай хуульд заасан хугацаанд багтаан гомдол, нэхэмжлэл гаргана.
- 4.3. Үйл ажиллагаагаа хуульд нийцүүлэх үүднээс шаардлагатай эрх зүйн нийцлийн тогтолцоо, компанийн засаглалыг нэвтрүүлэх, нийцэл, компанийн засаглал хариуцсан ажилтантай байх эсвэл тус үйлчилгээг гэрээний үндсэн дээр авах.

### **V. Үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд үнэнч байх**

- 5.1. Даатгалын брокер нь үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд үнэнч байх зарчмын хүрээнд дараах шаардлагуудыг биелүүлнэ.
  - 5.1.1. Мэргэжлийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь үйлчлүүлэгчийн ашиг сонирхол байх бөгөөд даатгалын зуучлагч нь үйлчлүүлэгчийн ашиг сонирхлын төлөө шударга, тууштай ажиллана.
  - 5.1.2. Даатгалын зуучлагч нь үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд түүнтэй ярилцах, сонсох, үйл ажиллагааг нь судлах, санхүүгийн баримтуудтай танилцах, даатгалын зүйл, ашиг сонирхлыг судлах зэргээр түүнд шаардлагатай, тохирох даатгалын хамгаалалт, бүтээгдэхүүнийг тодорхойлоход шаардлагатай арга хэмжээг авна.
  - 5.1.3. Даатгалын зуучлагч нь боломжит өргөн хүрээнд санал авч, өөрийн үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд бүрэн тохирно гэж үзсэн даатгалын хамгаалалт, бүтээгдэхүүний хэд хэдэн хувилбарыг үйлчлүүлэгчид санал болгож, түүний саналыг сонсоно.
  - 5.1.4. Даатгалын гэрээний төслийг үйлчлүүлэгчид санал болгох, зөвлөгөө өгөхөд хангалттай цаг хугацаа зарцуулж, үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг хамгаалж чадах эсэх талаар няхуур ажиллана.
  - 5.1.5. Үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд үнэнч, тууштай байхад харшлах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үүсгэхгүй байх, бие даасан, хараат бус байдлаар ажиллана.

#### **VI. Сонирхлын зөрчлөөс сэргийлэх**

- 6.1. Даатгалын зуучлагч нь сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарчмын хүрээнд дараах шаардлагыг дагаж мөрдөнө.
  - 6.1.1. Үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд харшлах, түүнтэй зэрэгцэх, өрсөлдөх аливаа сонирхлын зөрчилд орохгүй, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.
  - 6.1.2. Сонирхлын зөрчилд тооцогдож болзошгүй, үйлчлүүлэгч тийнхүү эргэлзэж болох асуудлаар үйлчлүүлэгчид тухай бүрт нь мэдэгдэх арга хэмжээ авна.
- 6.2. Ашиг сонирхлын зөрчил гэдэгт дараах тохиолдлуудыг ойлгоно:
  - 6.2.1. Үйлчлүүлэгчийн өмнөөс харилцах нөгөө талын өмнө хүлээсэн үүрэг, хүлээгдэж буй төлбөр, шан харамж, хүлээж болох торгууль, хохирол зэргээс болж үйлчлүүлэгчийн ашиг сонирхлын төлөө тууштай ажиллах боломж, нөхцөл хязгаарлагдах бол;
  - 6.2.2. Үйлчлүүлэгчийн өмнөөс харилцах нөгөө талтай ашиг хуваах гэрээ, хэлцэлтэй, эсвэл түүний хувьцааг нь шууд болон дамжмал байдлаар эзэмшдэг, хамаарал бүхий компани бол эсвэл түүний хувьцаа эзэмшигч, удирдлагын багийн гишүүнтэй гэр бүлийн болон бусад байдлаар дотно харилцаатай бөгөөд тус харилцаа нь үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулахаар бол;
  - 6.2.3. Даатгалын зуучлагч, түүний гүйцэтгэх захирал, төлөөлж ажиллах ажилтан нь үйлчлүүлэгчийн өмнө хугацаа хэтэрсэн өр төлбөртэй бол;

- 6.2.4. Даатгалын зүйл нь даатгалын зуучлагчийн барьцаа хөрөнгөөр бүртгэгдсэн тохиолдолд;
- 6.2.5. Даатгалын зуучлагч, түүний ажилтан зуучлагдан даатгуулсан зүйлд ашиг сонирхол бүхий байх нөхцөлд;

### **VII. Мэргэжлийн шаардлага хангасан байх**

- 7.1. Даатгалын зуучлагч нь мэргэжлийн шаардлага хангасан байх зарчмын хүрээнд дараах шаардлагуудыг хангаж ажиллана.
  - 7.1.1. Мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай мэдлэг, ур чадварыг урьдчилан эзэмшсэн байх, тасралтгүй суралцах, хөгжүүлэх арга хэмжээ авна.
  - 7.1.2. Өөрийн үзүүлж буй үйлчилгээний хүрээнд шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшсэн ажилтантай байх эсвэл гэрээгээр тус үйлчилгээг авахаар урьдчилан тохиролцсон байх;
  - 7.1.3. Мэргэжлийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах техник, технологи, программ хангамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байх;
  - 7.1.4. Салбарын хүрээнд шинээр батлагдсан хууль тогтоомжуудыг судалж мэдэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг судлах, салбарын өөрчлөлт, шинэчлэлт, мэдээллүүдийг тогтмол судлах;
  - 7.1.5. Зохицуулах байгууллагаас болон Холбооноос тогтоосон сургалтын кредит цагыг хангаж, төлөөлж ажиллах ажилчдаа сургалтад хамруулах;
  - 7.1.6. Энэхүү дүрмийг өөрийн үйл ажиллагаанд баримтлах, хэвшүүлэх, үүний тулд төлөөлж ажиллах ажилчиддаа энэ талаар танилцуулж, сургалт орсон байх;
  - 7.1.7. Даатгагчийн санхүүгийн чадвар, төлбөрийн чадвар үзүүлэлтийг уншиж ойлгох санхүүгийн мэдлэгтэй байх;
  - 7.1.8. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай аливаа мэргэжлийн нэр томъёо, ойлголтыг урьдчилан эзэмшиж, түүний үйлчлүүлэгчид энгийн, ойлгомжтой байдлаар тайлбарлах чадварыг эзэмшсэн байх;
  - 7.1.9. Даатгалын зуучлагчийг төлөөлж ажиллах ажилчид энэхүү дүрмийн шаардлагыг биелүүлж ажиллаж буй эсэхийг нягтлах дотоод хяналтыг хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа дүрэмд нийцүүлэх тухай шаардлага тавьж байх;
  - 7.1.10. Үйлчлүүлэгчийн даатгуулахыг хүсч буй ашиг сонирхлыг даатгагч даатгах чадвартай эсэх, хэрэв чадваргүй бол санхүүгийн чадвар бүхий давхар даатгалаар хамгаалагдсан эсэх, даатгагчийн төлбөрийн чадвар үзүүлэлт хангагдаж буй эсэх болон даатгагчийн тусгай зөвшөөрөл цуцлагдах, дампуурах бодит эрсдэл байгаа эсэхийг нягтална.
  - 7.1.11. Үйлчлүүлэгчид даатгалын бүтээгдэхүүн нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх даатгагч нь тухайн төрлийн даатгалын туршлагатай эсэх, тус үйлчилгээг үзүүлэх мэдлэг, чадвар бүхий ажилтантай эсэхийг нягтална.

### **VIII. Үйлчилгээний нууцлалыг хадгалах**

- 8.1. Даатгалын зуучлагч нь Үйлчилгээний нууцлалыг хадгалах зарчмын хүрээнд дараах шаардлагуудыг хангаж ажиллана.
  - 8.1.1. Мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах болон хууль хяналтын байгууллагын шаардсаны дагуу ашиглахаас бусад байдлаар ашиглахгүй, задруулахгүй байх.
  - 8.1.2. Өөрсдийн ажиллах ажлын байр, интернет орчинд үйлчилгээний нууцлал алдагдахгүй байх нөхцөл бүрдүүлж ажиллах;
- 8.2. Үйлчилгээний нууцлалд үйлчлүүлэгч болон боломжит үйлчлүүлэгч, харилцагч компанийн нууцлал хамаарна.
- 8.3. Аливаа этгээд даатгалын нөхөн төлбөрийн хууль бусаар авах болон бусад байдлаар гэмт хэрэг үйлдэх гэж байгаа гэж үзэх үндэслэл байвал түүнийг цагдаагийн байгууллагад мэдэгдэх нь үйлчилгээний нууцлал задруулсан гэж үзэх үндэслэл болохгүй.
- 8.4. Үйлчилгээний нууцлал хадгалах үүрэг нь үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээ цуцлагдсан, дуусгавар болсон эсэхээс үл хамааран хугацаагүй байна.

### **IX. Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх**

- 9.1. Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх зарчмын хүрээнд даатгалын зуучлагч нь дараах шаардлагуудыг хангаж ажиллана.
  - 9.1.1. Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөхөд шаардлагатай мэдлэг, ур чадвар эзэмшсэн байх;
  - 9.1.2. Үйлчлүүлэгч шийдвэр гаргахад ач холбогдолтой, шаардлагатай, түүний тодруулсан, эргэлзсэн асуудлаар үнэн зөв, бүрэн, ойлгомжтой байдлаар зөвлөгөө өгнө.
  - 9.1.3. Үйлчлүүлэгч тусгайлан зөвшөөрөл олгоогүй бол түүний өмнөөс шийдвэр гаргахгүй, гагцхүү түүнд шийдвэр гаргахад шаардлагатай зөвлөө өгч, туслана.
  - 9.1.4. Үйлчлүүлэгчийн сонгох гэж буй даатгалын бүтээгдэхүүний дагуу хамгаалагдах ашиг сонирхол, хамгаалагдах эрсдэл болон даатгалд хамрагдахгүй нөхцөл, хэсгүүд, даатгалын гэрээний дагуу түүний хүлээх үүргийн талаар үйлчлүүлэгчид тайлбарлаж өгнө.
  - 9.1.5. Үйлчлүүлэгчид өгөх зөвлөгөө нь үнэн зөв, шийдвэр гаргахад ач холбогдол бүхий асуудлыг бүрэн хамарсан, үйлчлүүлэгчид ойлгомжтой энгийн хэллэгээр илэрхийлэгдсэн байх шаардлагатай.
  - 9.1.6. Хэрэв даатгалын зуучлагч нь зөвлөгөө өгөх явцад тодорхой бус, эргэлзээтэй, өөрийн мэдэхгүй асуудал гарвал энэ талаар үйлчлүүлэгчид мэдэгдэнэ.

- 9.1.7. Үйлчлүүлэгч нь харилцагчид зөвлөгөө өгөх үүрэггүй боловч түүний хүсэлтээр зөвлөгөө өгөх нөхцөлд үнэн зөв зөвлөгөө өгч, даатгалын зуучлагч нь өөрийн үйлчлүүлэгчийн төлөө ажиллах этгээд болох талаар түүнд ойлгомжтой тайлбарлах үүрэгтэй.
- 9.1.8. Даатгалын зуучлагч нь өөрийн үйлчлүүлэгч бус этгээдэд зөвлөгөө, мэдээлэл өгөхдөө түүнд буруу, дутуу мэдээлэл, зөвлөгөө өгөх, шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлыг нуун дарагдуулах, төөрөгдүүлэхийг хориглоно.
- 9.1.9. Даатгалын зуучлагч нь өөрийн үйлчлүүлэгчид хэд хэдэн даатгалын бүтээгдэхүүн санал болгох бол тэдгээрийн төстэй болон ялгаатай тал, онцлог, үйлчлүүлэгчийн сонирхолд нийцтэй байдлыг нь тайлбарлаж өгөх бөгөөд үйлчлүүлэгч шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлыг орхигдуулахгүй.
- 9.1.10. Мэргэжлийн үйл ажиллагааг явуулах явцад үйлчлүүлэгчийн гаргах гэж буй шийдвэр, аливаа үйлдэл, эс үйлдэхүйн үр дагавар, учирч болох эрсдэл, давуу, сул талыг түүнд тайлбарлаж өгнө.
- 9.1.11. Даатгалын зуучлагч нь үйлчлүүлэгчид аливаа гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл хийх талаар зөвлөгөө өгөх, оролцохыг хориглоно.

#### **Х. Ил тод, нээлттэй байх, мэдээллээр хангах**

- 10.1. Ил тод, нээлттэй байх, мэдээллээр хангах зарчмын хүрээнд даатгалын зуучлагч нь дараах шаардлагуудыг хангаж ажиллана.
- 10.2. Даатгалын зуучлагч нь өөрийн үйлчлүүлэгчид дараах мэдээллийг заавал өгнө:
  - 10.2.1. Даатгалын зуучлагчийн албан ёсны бүртгэлтэй нэрийг бүтэн байдлаар;
  - 10.2.2. Даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрлийн дугаар;
  - 10.2.3. Даатгалын зуучлалын тусгай зөвшөөрлийн хэлбэр, хамрах хүрээ;
  - 10.2.4. Хуулийн этгээдийн төрөл, хэлбэр;
  - 10.2.5. Албан ёсны бүртгэлтэй болон бүртгэлгүй боловч төв оффис нь байршиж буй хаягын мэдээлэл;
  - 10.2.6. Даатгалын зуучлагчийг төлөөлж ажилласан ажилтны овог, нэр, албан тушаал.
  - 10.2.7. Даатгалын зуучлагч болон төлөөлж ажилласан ажилтантай харилцах цахим шуудангийн хаяг эсвэл утасны дугаар.
- 10.3. Даатгалын зуучлагч нь харилцагчид төөрөгдөл үүсгэхгүй байх үүднээс дараах шаардлагыг хангаж ажиллана.
  - 10.3.1. Даатгалын зуучлагч нь харилцагч этгээдтэй харилцахдаа түүнийг төлөөлж, түүний ашиг сонирхлын төлөө ажиллах, зөвлөгөө өгөх үүрэгтэй этгээд биш болох талаар тодорхой тайлбарлана.
  - 10.3.2. Харилцагч нь даатгалын зуучлагчийг өөрийн ашиг сонирхлын төлөө ажиллах этгээд гэж буруу ойлгосон талаар мэдсэн, мэдэх ёстой байсан бол түүний буруу ойлголтыг засах, залруулах арга хэмжээ авна.

- 10.3.3. Харилцагчийн хүсч буй асуудлаар зөвлөгөө өгөх нь даатгалын зуучлагчийн үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх бол энэ талаар зөвлөгөө өгөхөөс татгалзаж, бусад этгээдээс зөвлөгөө авахыг түүнд санал болгоно.
- 10.4. Хэрэв даатгалын зуучлагч нь хэд хэдэн этгээдийг төлөөлж ажиллаж байгаа бол аливаа үйлдэл хийх бүрт тухайн тохиолдолд хэнийг төлөөлж буйгаа нөгөө талдаа ил тод, ойлгомжтой тайлбарлана.
- 10.5. Даатгалын зуучлагч нь өөрийн үйлчлүүлэгчид даатгалын бүтээгдэхүүн санал болгож буй нөхцөлд даатгагчийн албан ёсны нэр, даатгалын бүтээгдэхүүний нэр, хамгаалагдах ашиг сонирхол, эрсдэл, даатгалд хамрагдахгүй нөхцөл, хэсэг, даатгалын хугацаа, даатгалын хураамжийн дүн, түүнийг төлөх журам болон үйлчлүүлэгч шийдвэр гаргахад ач холбогдол бүхий бусад мэдээллийг үйлчлүүлэгчид өгнө.
- 10.6. Даатгалын зуучлагч нь үйлчлүүлэгчид үзүүлж буй үйлчилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны төлөө үйлчлүүлэгч бус харилцагч бусад этгээдээс аливаа байдлаар төлбөр, хөлс авч байгаа, эсвэл тийнхүү гэрээтэй бол энэ талаар түүнд үйлчилгээ үзүүлэхээс өмнө мэдээлнэ.
- 10.7. Даатгалын зуучлагч нь үйлчлүүлэгчтэй хамтран ажиллахдаа бичгээр гэрээ байгуулж, өөрийн хүлээх үүрэг, хариуцлага, тэдгээрийн хязгаарлалт, үйлчилгээний үнэ хөлс, түүний төлөгдөх журам, мэргэжлийн үйл ажиллагааг энэхүү журамд үндэслэн явуулах тухай тодорхой тусгана. Үйлчлүүлэгч нь иргэн байх нөхцөлд дүрмийн энэхүү шаардлага тавигдахгүй.
- 10.8. Хэрэв үйлчлүүлэгч хүссэн нөхцөлд даатгалын зуучлагч нь өөрийн болон төлөөлж ажиллах ажилтнуудын туршлага, мэдлэг, ур чадварын талаар үнэн зөв мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.
- 10.9. Даатгалын зуучлагч нь аливаа сурталчилгаа явуулахдаа худал, бусдыг төөрөгдүүлэх агуулгатай сурталчилгаа явуулахгүй.
- 10.10. Даатгалын зуучлагч нь өөрийн үйлчлүүлэгчид мэргэжлийн үйл ажиллагаанаас бусад төрлийн үйлчилгээ үзүүлж буй бол тус үйлчилгээ нь даатгалын зуучлалын мэргэжлийн үйл ажиллагаанд хамаарахгүй тухай тайлбарлаж өгнө.
- 10.11. Даатгалын зуучлагч нь үйлчлүүлэгчид үзүүлж буй үйлчилгээний хүрээнд хийгдсэн ажлын үйл явцын тухай мэдээллийг үйлчлүүлэгчид тогтмол, цаг тухайд нь тайлагнаж, ажлын явцад түүний саналыг авч байна.



- 10.12. Даатгалын зуучлагч нь дараах үндэслэл, тохиолдолд үйлчлүүлэгчид мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхгүй байх үүрэгтэй.
- 10.12.1. Үйлчилгээ үзүүлэх нь энэхүү дүрмийн шаардлагыг зөрчихөөр бол;
- 10.12.2. Үйлчилгээ үзүүлсэнээр ашиг сонирхлын зөрчилд хүргэхээр бол;

#### **XI. Даатгалын нөхөн төлбөр нэхэмжлэх үйлчилгээ**

- 11.1. Даатгалын зуучлагч нь өөрийн үйлчлүүлэгчийг даатгалын нөхөн төлбөр нэхэмжлэх ажиллагаанд төлөөлөх, тус асуудлаар зөвлөгөө үзүүлэх бол энэхүү дүрмийн нийтлэг шаардлагуудыг хангахаас гадна доор дурдсан шаардлагуудыг хангаж ажиллана. Үүнд:
- 11.1.1. Даатгалын гэрээ, даатгалын тохиолдол, түүнд холбогдох бичиг баримтуудын талаар судалж, даатгалын гэрээгээр хамгаалагдах эрсдэл мөн эсэх талаар дүн шинжилгээ хийж, үйлчлүүлэгчид танилцуулна.
- 11.1.2. Үйлчлүүлэгчээс авсан мэдээлэлд үндэслэн даатгалын нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг боловсруулж түүнд танилцуулж, саналыг нь авах, эсвэл түүний боловсруулсан даатгалын нөхөн төлбөрийн нэхэмжлэлд зөвлөгөө өгнө.
- 11.1.3. Даатгалын гэрээгээр хамгаалагдсан зохих, зөв эрсдлийг сонгож, даатгалын нөхөн төлбөрийг Даатгалын гэрээнд заасан хугацаанд бүрэн нэхэмжлэнэ.
- 11.1.4. Даатгалын нөхөн төлбөрийн баримтуудыг бүрдүүлж өгөх үед болон нөхөн төлбөр шийдвэрлэх явцад нөхөн төлбөрийг шийдвэрлэхэд шаардлагатай бусад баримт, мэдээлэл хэрэгтэй эсэхийг даатгагчаас асууж, даатгагчийн шаардлага, хүсэлтэд даатгуулагчийн ашиг сонирхолд нийцүүлэн хурдан шуурхай харну өгнө.
- 11.1.5. Даатгалын гэрээнд заасан хугацаанаас хэтрүүлэхгүйгээр, даатгуулагчийн хүссэн хугацаанд эсвэл хурдан шуурхай байдлаар даатгалын нөхөн төлбөр шийдвэрлэлтийн талаар хариуг бичгээр авах талаар шаардлагатай арга хэмжээг авна.
- 11.1.6. Даатгагчаас өгсөн даатгалын нөхөн төлбөр шийдвэрлэлтийн талаарх хариу, шийдвэр нь даатгуулагчийн ашиг сонирхолд бүрэн болон хэсэгчлэн нийцээгүй бол энэ талаар дахин судалж, үйлчлүүлэгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Санхүүгийн зохицуулах хороонд хандах арга хэмжээ авна.
- 11.1.7. Даатгуулагчийн ашиг сонирхлын төлөө Санхүүгийн зохицуулах хороонд хандах бол даатгагчийн нөхөн төлбөр олгохоос татгалзаж буй үндэслэлийг няцаах үндэслэл, түүнд холбогдох баримтуудыг хангалтай, бүрэн бүрдүүлж, ойлгомжтой байдлаар тайлбарласан байна.
- 11.1.8. Үйлчлүүлэгч нь даатгалын нөхөн төлбөр шийдвэрлэлтийн талаар хууль зүйн үйлчилгээ авахыг хязгаарлах үйлдэл гаргахгүй бөгөөд тэрээр хуульч ажиллуулж буй нөхцөлд даатгалын зуучлагч нь үйлчлүүлэгчийн хуульчтай хамтран ажиллана.

11.1.9. Даатгалын нөхөн төлбөр шийдвэрлэлтийн талаар зөвлөгөө өгөхдөө даатгалын зуучлагчаас үзүүлэх үйлчилгээний хүрээг энэхүү дүрэмд зааснаас хязгаарлаж болох бөгөөд энэ тохиолдолд бичгээр байгуулсан гэрээнд энэ талаар тодорхой тусгасан байна.

## **ХИИ. Бусад**

- 12.1. Даатгалын зуучлагч нь энэхүү дүрмийг зөрчсөн гэж үзсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэх журмыг Холбооны удирдах зөвлөлөөр баталж мөрдүүлнэ.
- 12.2. Энэхүү ёс зүйн дүрмийг Холбооны Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсанаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.
- 12.3. Даатгалын зуучлагч байгууллагууд энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.
- 12.4. Холбоо энэхүү дүрэм, дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн Холбооны гишүүн болон гишүүн бус байгууллагад хариуцлага ногдуулах, тусгай зөвшөөрлийг цуцлуулахаар СЗХ-нд санал оруулах арга хэмжээ авна.
- 12.5. Холбооноос батласан ёс зүйн дүрмийг СЗХ-д танилцуулж Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 29 дүгээрт заасны дагуу СЗХ-гоор батлуулна.